

АЖИГЛАГЧИЙН БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ

1. Сонгуулийн Ерөнхий хорооны 2021 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Сонгууль ажиглах нийтлэг журам” болон тус хорооны 2021 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн 59, 60 дугаар тогтоолоор тус тус баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 18, 28 дугаар тойрогт явагдах УИХ-ын гишүүний нөхөн сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах цаг хугацааны хуваарьт заасны дагуу **ажиглагчаар бүртгүүлэх хүсэлтээ 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдрөөс өмнө бичгээр гаргаж, хэсгийн хороонд хүргүүлнэ.**

Бүрдүүлэх бичиг баримт:

- Ажиглагчаар томилсон шийдвэрийн хуулбар;
 - Маягтын дагуу гаргасан ажиглагчийн өргөдөл;
 - Нэг хувь 3х4 хэмжээтэй цээж зураг;
 - Иргэний үнэмлэхийн хуулбар;
 - Ёс зүйн дүрмийг дагаж мөрдөхөө илэрхийлсэн гарын үсэг зурсан уг дүрмийн хуулбар.
2. Гадаадын болон Олон Улсын байгууллага, гадаад улсаас Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчийн газар, гадаад улсын иргэн /цаашид “гадаадын ажиглагч” гэх/ сонгууль ажиглах, ажиглагчаар бүртгүүлэх хүсэлтээ дараах баримт бичгийн хамт цаасан, эсхүл цахим хэлбэрээр Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлнэ. Үүнд:
 - ажиглагчаар томилсон тухай холбогдох байгууллагын албан хүсэлт;
 - маягтын дагуу гаргасан ажиглагчийн өргөдөл;
 - нэг хувь 3х4 хэмжээтэй цээж зураг;
 - гадаад паспортын хуулбар;
 - Ёс зүйн дүрмийг дагаж мөрдөхөө илэрхийлсэн гарын үсэг зурсан уг дүрмийн хуулбар.

Сонгууль ажигласан этгээд ажиглалтын тайлангаа зөвлөмжийн хамт Сонгуулийн ерөнхий хорооны gecm@gec.gov.mn цахим хаягаар хүргүүлнэ. Хэсгийн хороо хүсэлтийг хүлээн авч нягтлан шалгаж, санал авах өдрөөс хоёроос доошгүй хоногийн өмнө буюу **2021 оны 10 дугаар сарын 08-ны өдрөөс өмнө ажиглагчийн үнэмлэх олгоно.**